

ГЭР БҮЛИЙН ВИЗ

Японы хууль зүйн яамны Гадаад иргэдийн хэрэг эрхлэх газрын цахим хуудас дээрээс Гэр бүлийн виз гаргуулахад шаардлагатай бичиг баримтын жагсаалтыг харах боломжтой.

Гэвч энэхүү бичиг баримтууд нь хамгийн наад захын шаардлагатай бичиг баримт бөгөөд эдгээр бичиг баримтаас илүү олон баталгаа бичиг гаргаж өгвөл зөвшөөрөл авахад хялбар байна.

Мөн шаардлагатай бичиг баримтыг бүрдүүлж өгсөн ч дахин нэмэлт бичиг баримт шаардах, нэмэлт бичиг баримт дутуу бол зөвшөөрөл олгохгүй тохиолдол байдаг.

ОРШИН СУУХ ЗӨВШӨӨРӨЛ АВАХАД БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТ

*Өргөдөл гаргагч(申請人) нь Япон улсад оршин суух хүсэлтэй гадаадын иргэнийг хэлнэ.

*Тэжээгч(扶養者) гэдэг нь дээрх өргөдөл гаргагчийг Япон улсад асран хамгаалах гадаадын иргэнийг хэлнэ.

*Япон улсад үйлдэгдсэн бүх албан бичиг нь үйлдэгдсэн он сар өдрөөс хойш 3 сарын дотор хүчинтэй байна.

Виз мэдүүлэхэд шаардлагатай бичиг баримт

1. Албан байгууллага

Үндсэн ажилтны визтэй тохиолдолд ажиллаж буй албан байгууллагын бичиг баримт мөн шаардагдана. Үүнд:

- Компанийн гэрчилгээ (履歴事項全部証明書)
- Ажлын газрын тодорхойлолт (在職証明書)

*Доорх бичиг баримт нь нэмэлтээр шаардагдах тохиолдол байдаг.

- Байгууллагын ашиг орлогын хүснэгтийн хуулбар (法定調書合計表のコピー)
- Компанийн танилцуулга (会社案内)
- Жилийн эцсийн тайлан (直近の決算報告書)
- Бусад нэмэлтээр шаардагдах бичиг баримт

2. Өргөдөл гаргагчийн бүрдүүлэх бичиг баримт

- Оршин суух зөвшөөрөл хүсэгчийн өргөдөл (在留資格認定証明書交付申請書)
(Татах: <http://www.moj.go.jp/content/001290048.pdf>)
- Цээж зураг (4смХ3см хэмжээтэй)
 - *Өргөдөл гаргахаас 3 сарын дотор авахуулсан зураг байна.
 - *Цээж зургийн арын талд өргөдөл гаргагчийн нэрийг бичээд өргөдөл дээр наана.
- Паспортын хуулбар

- Хүсэлт гаргах шалтгаан (Япон хэл рүү орчуулсан байх)
- Өөрийн намтар
- Гадаад улсад үйлдэгдсэн гэр бүлийн бүртгэлийн гэрчилгээ, төрсөний гэрчилгээ
- Бусад шаардлагатай бичиг баримт

3. Тэжээгчийн бүрдүүлэх бичиг баримт

- Гадаад иргэний үнэмлэхний хуулбар (在留カードのコピー)
- Оршин суугчийн татварын гэрчилгээ (住民税課税証明書)
- Оршин суугч болон орлогын албан татвар төлсөн гэрчилгээ
Тухайн харьяа оршин суух хот дүүргээсээ гаргуулж авна.
(住民税又は所得税の納税証明書 (現在お住まいの市区町村の区役所・市役所・役場から発行されます。))
- Татвар суутгалын маягт (源泉徴収票)
- Япон дахь оршин суугаа хаягийн гэрчилгээ (日本での居所を証する書類)

Бусад

Хариу буцаах дугтуй. (404 иений марк наасан байх.)